



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Орхон сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БУА-2020/6/-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.bulgan@audit.mn

Булган аймаг
2020 он

Булган аймаг дахь Төрийн аудитын газрын
тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр
Утас:90900910 Цахим хаяг: Ankhbayard@audit.gov.mn
Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 99057478 Цахим хаяг:Enhtsoodolj@audit.gov.mn
Гэрээт аудитор: П.Эрдэнэзул
Утас:99812414 Цахим хаяг: Erdenezulp@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	10
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	11
2.13. Шилэн дансны мэдээлэл	11
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	11
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	11
Менежментийн захидал.....	12
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	15
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	15
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	18
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	22
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	26
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	27
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	Error! Bookmark not defined.



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2020.03.24 № 128

танай _____-ны № _____ т

ОРХОН СУМЫН ЗАСАГ
ДАРГА С.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Орхон сумын Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Орхон сумын Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Орхон сумын Засаг даргын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Орхон сумын Засаг дарга нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн

• 006020227

тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

Аудитын тайлан

2.1. Оршил

Орхон сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Засаг дарга С.Бат-Эрдэнэ танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тэшиг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 09-өөс 2020 оны 03 дугаар сарын 11-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Булган аймаг дахь Төрийн аудитын газрын гэрээт аудитор П.Эрдэнэзул хариуцаж хэрэгжүүлэв.

Орхон сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт баталгаажуулан ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Төрийн аудитын байгууллагаас

санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Орхон сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь Нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд төрийн албаны хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах мэргэшсэн мэдлэг чадвар бүхий албан хаагчаар бэхжүүлсний үндсэн дээр манлайлагч аппрадыг бүрдүүлж байгууллага хувь хүмүүсийн үйл ажиллагаанд идэвх санаачилгыг удирдан чиглүүлэх замаар сумын эдийн засгийн чадавх оршино.

ЗДТГ ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төрийн үйлчилгээг иргэдэд хөнгөн шуурхай хүргэх.
- Ил тод байх
- Зарчимч шударга байна

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Төрийн албаны тухай хууль / шинэчилсэн найруулга/
- Төсөв баталсан Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоол
- Төсөв баталсан Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоол
- Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоол Журам батлах тухай(Төрийн албан хаагчид шагнал олгох, ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн мөнгөн урамшуулал олгох)
- Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоол Журам батлах тухай(Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох)
- Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол Журам батлах тухай(Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл олгох)
- Сангийн сайдын 2018 оны 9 дүгээр сарын 12 -ны өдрийн 228 дугаар тушаал (Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам)
- Сангийн сайдын 2007 оны 11 дугаар сарын 30 -ны өдрийн 326 дугаар тушаал (Журам батлах тухай Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Орхон сумын төсөвт байгууллагууд санхүүгийн алба нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Сангийн яамны ЗГУТСистем, СТС ХХК-ны НББ-ийн программ, нярвын программ хангамж ашигладаг байна.

Орхон сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Орхон сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 3 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 2483001.4 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 49660.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 49660.0 мянган төгрөгөөр тооцлоо.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Орхон сумын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 111362.1 мянган төгрөгөөр буюу 103.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилж гарсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	88684.8	126536.7	37851.9
Авлага	376423.9	342538.8	-33885.0
Урьдчилгаа			
Бараа материал	191813.4	197569.7	5756.3
Үндсэн хөрөнгө	2351373.9	2453013.1	101639.2
Нийт хөрөнгө	3008296.2	3119658.3	111362.1
Өр төлбөр	22848.2	13648.8	9199.4
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	879562.1	879562.1	
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3008296.2	3119658.3	111362.1

Авлага дансны үлдэгдэл буурсан нь Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт 33885.0 мянган төгрөг авснаас шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс шалтгаалан 2011-2019 онуудад үүссэн, он удаан жил болсон 342538,8 мянган төгрөгийг хувь хүнээс авах авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь бараа материал нэмэгдсэнээс шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэл 2019 онд худалдаж авсан 184444.0 мянган төгрөгийн бараа материал байна. Оны эцэст 197569.7 мянган төгрөгийн худалдан авалт хийж бараа материалын нөөц үүсгэсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь Суманд спорт заал 222930.4 мянган төгрөг, ЗДТГын үйлчилгээнд авто машин 60000.0 мянган төгрөгөөр, Сургуулийн гал тогооны их засвар 6000.0 мянган төгрөгөөр тус тус худалдан авч, барьж засварласнаас шалтгаалжээ. Аймгийн засаг даргын эрх шилжсэн ОНХС Хөрөнгө оруулалтаар 272930.4 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй хүлээн 33099.1 мянган төгрөгийн эх үүсвэрээс бүрдсэн байна. Нийт өссөн буурсны зөрүүгээр 101639.2 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлсэн 32000.0 мянган төгрөг, акталсан 20002.9 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 9199.4 мянган төгрөгөөр буурсан нь Байгууллагат өгөх өглөгийг төлж барагдуулснаас шалтгаалжээ

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3106009.5 мянган төгрөг болж 120561,6 мянган төгрөгөөр өссөн нь хөрөнгө нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга 3186.5 мянган төгрөгийн бичилт нь өмнөх үеийн үр дүнрүү хаасан бичилттэй холбоотой байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Санхүүгийн алба тайлант онд 114691.6 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 150072.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 130.8 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын нэр төрөл	төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү	Хувь
Үйл ажиллагааны орлого	1500.0	7089,3	5589.3	472.6
Иргэний ҮХХБАТ		400,0	400.0	
Хадгаламжийн хүү	8900.0	12843,3	3943.3	144.3
Шууд бус орлого	25640.0	32203.3	6563,3	125.6
Бууны татвар	3084.0	1992.0	-1092	64.5
Улсын тэмдэгт	5979.0	5495.1	483,9	91.9
Ойн гоожин	31373,8	31901.9	181,9	101.6
Түгээмэл тархацтай ашигт малтмал	8200.0	22552.0	14352	275.0
Ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглахад олгох эрхийн зөвшөөрлийн хураамж	1000.0	519.2	-419.2	51.9
Ус рашаан	980.0	1912.5	932.5	51.2
Хог хаягдал	6670.8	7961.7	1290.9	119.3
Хүү торгуул	19000.0	23796.9	4796.9	237.9
ТБӨО	1000.0	967.4	-32,6	96.7
Нийт дүн	114691.6	150072.9	35381.3	130.8

Төсвийн орлого 35381.0 мянган төгрөгөөр давсан нь Орхоноос Хишиг Өндөрийн чиглэлийн хатуу хучилттай засмал замаас элс хайрга авсан нь түгээмэл тархацтай ашигт малтмалын орлого, хүү торгуулийн орлого, Сумын 60 жилийн ойн баяр наадмын бүтээн байгуулалтын ажлуудаас орсон шууд бус орлогын албан татвараас шалтгаалсан байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 1867147.6 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1667300,5 мянган төгрөгийг урсгал зардалд 75000.4 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулсан

Нийт зардлын 959762,3 мянган төгрөгийг улсын 679866.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 29100,4 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 00 мянган төгрөгийг Нийгмийн даатгалын сангаас, 198418,0 мянган төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Зардлыг санхүүжүүлэх орлогын нэр төрөл тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжүүлэх 959762.3 мянган төгрөгөөс 915072.3 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 623625.6 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээс 633257.3 мянган төгрөгөөр ЭМД-аас 29100.4 мянган төгрөг авахаас 2082,6 мянган төгрөгийн санхүүжилтээр тус тус санхүүжсэн байна ЭМД-ийн санхүүжилт 27017,8 мянган төгрөгөөр дутуу санхүүжилт авсан байна

Урсгал зардлын төлөвлөгөө 1761927,6 мянган төгрөг зарцуулахаас 1563825.6 мянган төгрөг зарцуулсан Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалд 993898.0 мянган төгрөг зарцуулахаас 955264,7 мянган төгрөг , НДШ 124237.0 мянган төгрөг зарцуулахаас 123206.7 мянган төгрөг Байр ашиглалтын зардал 202145.9 зарцуулахаас 200183.6 мянган төгрөг, Хангамж бараа материалын зардал 58834.6 мянган төгрөг зарцуулахаас 54027.1 мянган төгрөг Норматив зардал 94526.6 мянган төгрөг зарцуулахаас 78672.3 мянган төгрөг, Эд хогшил урсгал зардалд 17647.3 мянган төгрөг зарцуулахаас 15771.8 мянган төгрөг Томилолтын зардалд 12117.3 мянган төгрөг зарцуулахаас 9140,2 мянган төгрөг Бусдаар гүйцэтгүүлсэн бусад үйлчилгээний зардалд 14032.5 12983,6 мянган төгрөг Бараа үйлчилгээний бусад зардал 114177.5 мянган төгрөг зарцуулахаас 114177,5 мянга төгрөг тус тус зарцуулж төсвийг хэмнэж ажилласан байна

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд 101641,3 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 75000.4 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1685014,6 мянган төгрөг буюу 90.2 хувьтай байгаа нь Төсвийн зардлыг хэмнэсэн байна.

Нэмэлт төсөв: Засгийн газрын нөөц сан/Засаг даргын нөөц хөрөнгө/-гаас 344086.3 мянга, дээд шатны төсвийн захирагчаас 21645.2 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 1000.2 мянга, нийт 366731.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс 1685014.6 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 46381.7 мянган төгрөгийг улсын төсөвт 1048.1 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 3 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 0 эрсдэл тодорхойлж нийт 3 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар илэрсэн 35381.3 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Орхон сумын Засаг даргын санхүүгийн үйл ажиллагааг үр нөлөөтэй зохион байгуулах, дотоод хяналт, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна. Тухайлбал:

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг нийт дүнгээрээ 35381.3 мянган төгрөгөөр давж биелсэн, орлогыг нэр төрлөөр авч үзвэл үйл ажиллагааны орлого 5589.3, хувь хүний орлого 400.0, хөрөнгийн орлого 3943,3, шууд бус орлого 5663.3, Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 14352.0, хог хаягдлын үйлчилгээний хураамж 1290.9, ус рашааны нөөц ашигласны төлбөр 932.5, торгуулийн орлого 4796.9, Ойн нөөц ашигласны төлбөр 528.1 мянган төгрөгөөр тус тус давж биелсэн бол ан амьтны нөөц ашигласны төлбөр 26.0, төсөвт байгууллагын өөрийн орлого 32.5, тухай жилийн үйл ажиллагаанаас үл хамаарах бууны албан татвар 1092.0, улсын тэмдэгтийн хураамж 483.9 мянган төгрөгөөр тус тус тасалсан байна.

Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангаар нийт 70943.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсний 8298.5 мянган төгрөгт төлбөрийн акт тогтоож, 42634.4 мянган төгрөгт албан шаардлага бичиж, зөрчлийг давтан гаргахгүй байх 20010.0 мянган төгрөгийн зөвлөмжийг тус тус хүргүүлсэн байна.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Орхон сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 154 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 2 зөвлөмж өгснөөс 2 зөвлөмжийг хэрэгжүүлж, хэрэгжилт 100 хувьтай байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Орхон сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Орхон сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын **агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс** урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Орлогын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг нийт дүнгээрээ 35381.3 мянган төгрөгөөр давж биелсэн, орлогыг нэр төрлөөр авч үзвэл үйл ажиллагааны орлого 5589.3, хувь хүний орлого 400.0, хөрөнгийн орлого 3943,3, шууд бус орлого 5663.3, Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 14352.0, хог хаягдлын үйлчилгээний хураамж 1290.9, ус рашааны нөөц ашигласны төлбөр 932.5, торгуулийн орлого 4796.9, Ойн нөөц ашигласны төлбөр 528.1 мянган төгрөгөөр тус тус давж биелсэн бол ан амьтны нөөц ашигласны төлбөр 26.0, төсөвт байгууллагын өөрийн орлого 32.5, тухай жилийн үйл ажиллагаанаас үл хамаарах бууны албан

татвар 1092.0, улсын тэмдэгтийн хураамж 483.9 мянган төгрөгөөр тус тус тасалсан байна.

3.1.2 Эрсдэл:

Төлөвлөөгүй орлого орсноор зориулалт бус зардал гарах, төсвийн орлого тасарснаас эх үүсвэр дутагдах, хууль журам зөрчигдөх,

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 дэх “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухай төсвийн байгууллагын өөрийн орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах, жил бүрийн орлогын биелэлтэд дүн шинжилгээ хийж орлогыг бүрэн төлөвлөх, тасарсан орлого биелэх боломж байгаа эсэх талаар судалгаа хийж байх.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Саналгүй.

3.2 Төсвийн шууд захирагчтай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт

Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангаар нийт 70943.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсний 8298.5 мянган төгрөгт төлбөрийн акт тогтоож, 42634.4 мянган төгрөгт албан шаардлага бичиж, зөрчлийг давтан гаргахгүй байх 20010.0 мянган төгрөгийн зөвлөмжийг тус тус хүргүүлсэн байна.

3.2.2 Эрсдэл:

Хууль журам, зөрчигдөх, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн шууд захирагч, санхүү, бүртгэлийн ажилтны сахилга хариуцлагыг сайжруулах, дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллах.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Саналгүй

3.3 Удирдлагатай холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт:

Сумын Засаг дарга Боловсролын тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасан албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлэн Төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4 дэх заалтыг зөрчин цэцэрлэгийн эрхлэгчид Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг дүгнэж үр дүнгийн урамшуулал олгох шийдвэр гаргасан нь тус хуулийн 30 дугаар зүйлд заасан аймгийн Засаг даргын бүрэн эрхийг хэрэгжүүлсэн байна.

3.3.1 Эрсдэл:

Хууль журам, зөрчигдөх.

3.3.2 Өгсөн зөвлөмж:

Засгийн газрын 2016 оны 153-р тогтоолын хавсралтаар "Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам" мөрдөн ажиллах.

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Саналгүй

Төсвийн төврүүлэн захирагч зөвшөөрсөн дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар 20-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.АНХБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Ж.ЭНХЦООДОЛ

БЭЛТГЭСЭН:

ГЭРЭЭТ АУДИТОР

П.ЭРДЭНЭЗУЛ

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>656.922.224,97</u>	<u>666.645.261,32</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	88.684.830,51	126.536.709,38
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	5.561,60	-
31110	Төгрөг	5.561,60	
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	88.679.268,91	126.536.709,38
3121	Төгрөг	88.679.268,91	126.536.709,38
31211	Төрийн сангийн харилцах	88.658.830,51	126.469.376,59
31213	Арилжааны банк дахь харилцах	20.438,40	67.332,79
33	АВЛАГА	376.423.990,41	342.538.841,67
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	792.117,00	1.144.757,40
33300	Татаас, санхүүжилтийн авлага	13.890.465,00	
335	Бусад авлага	361.741.408,41	341.394.084,27
3351	Байгууллагаас авах авлага	2.871.301,00	3.707.860,00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	358.870.107,41	337.686.224,27
35	БАРАА МАТЕРИАЛ	191.813.404,05	197.569.710,27
351	Түүхий эд материал	51.987.703,08	51.724.735,63
35110	Тусгай зориулалттай материал	35.591.913,05	30.257.400,44
35130	Эм боох материал	16.395.790,03	21.467.335,19
35300	Бэлэн бүтээгдэхүүн		663.400,00
354	Хангамжийн материал	136.245.700,97	145.181.574,64
35410	Бичиг хэргийн материал	2.744.915,00	2.340.055,00
35420	Аж ахуйн материал	3.302.122,00	8.381.342,00
35430	Сэлбэг хэрэгсэл	46.000,00	1.346.000,00
35440	Түлш, шатах тослох материал	2.422.530,00	3.238.480,00

Орхон сумын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

35450	Барилгын засварын материал	8.702.050,00	4.780.600,00
35460	Хүнсний материал	6.251.645,62	12.880.298,29
35470	Бусад хангамжийн материал	112.776.438,35	112.214.799,35
35600	Мал амьтад	3.580.000,00	
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2.351.373.985,58</u>	<u>2.453.013.110,08</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2.351.373.985,58	2.453.013.110,08
391	Газар		
392	Биет хөрөнгө	2.229.626.902,24	2.332.707.259,93
39201	Барилга, байгууламж, орон сууц	1.541.073.407,05	1.772.103.884,05
39202	Хуримтлагдсан элэгдэл	(31.494.790,39)	(216.477.472,98)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	240.748.015,00	268.748.015,00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(139.635.357,01)	(133.622.610,33)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	256.809.392,74	295.658.788,24
39206	Хуримтлагдсан элэгдэл	(180.872.010,03)	(203.159.960,30)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	192.848.388,62	205.181.524,62
39208	Хуримтлагдсан элэгдэл	(114.377.360,23)	(115.966.385,87)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	1.921.960,00	1.921.960,00
39214	Бусад үндсэн хөрөнгө	420.898.674,72	414.916.874,72
39215	Хуримтлагдсан элэгдэл	(156.769.154,81)	(159.024.893,80)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	174.968.375,00	174.503.575,00
39217	Ном	23.507.361,58	27.923.961,58
393	Биет бус хөрөнгө	121.747.083,34	120.305.850,15
39301	Програм хангамж	5.597.000,00	4.797.000,00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(3.559.916,66)	(3.852.416,54)
39303	Бусад биет бус хөрөнгө	119.710.000,00	119.710.000,00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-	(348.733,31)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>3.008.296.210,55</u>	<u>3.119.658.371,40</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>22.848.284,83</u>	<u>13.648.830,10</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	22.848.284,83	13.648.830,10

413	Өглөг	22.848.284,83	13.648.830,10
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1.028.058,00	73.546,00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	739.248,00	-
4136	Бусад өглөг	21.080.978,83	13.575.284,10
41361	Байгууллагад төлөх өглөг	21.065.526,83	13.575.284,10
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	15.452,00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2.985.447.925,72</u>	<u>3.106.009.541,30</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2.985.447.925,72	3.106.009.541,30
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	879.562.126,62	879.562.126,62
512	Хуримтлагдсан үр дүн	896.745.472,15	1.017.307.087,73
51210	Өмнөх үеийн үр дүн	1.237.669.313,12	899.932.036,15
51220	Тайлант үеийн үр дүн	(340.923.840,97)	117.375.051,58
